

НЭР ДЭВШИГЧИЙН ӨРГӨДЛИЙН ЗАГВАР
/шүүгчээс бусад хуульч нэрээ дэвшүүлэх/

... оны сар-ны өдөр
хот

Улаанбаатар

.....-ны би анхан, давж заалдах (дугуйлах)
шатны шүүхийн эрүү; иргэн; захиргаа; эрүү, иргэний хэргийг (дугуйлах) харьяалан
шийдвэрлэдэг шүүхийн шүүгчийн албан тушаалд, Улсын дээд шүүхийн шүүгчийн
албан тушаалд (дугуйлах) нэрээ дэвшүүлж байна.

Миний бие Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн-т
заасан шүүгчид тавих болзол, шаардлагыг хангасан, сүүлийн зургаан жилд улс
төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй болно.

Шүүгчийн сонгон шалгаруулалтын шалгалтад нэр дэвшигчээр бүртгэсэн
тохиолдолд хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг олон нийтэд
нээлттэйгээр байршуулах, эрх бүхий байгууллагаас лавлагаа тодруулга авахад
татгалзах зүйлгүй болохоо илэрхийлж байна.

Шүүгчийн сонгон шалгаруулалтын нөөцөд бүртгэлтэй, үнэлгээ нь хүчинтэй
байгаа, тохиолдолд дахин оролцсон шалгалтын нийлбэр оноогоор
эрэмбэлэгдэхийг хүлээн зөвшөөрсөн болно. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр
дэвшигч би эрүү, иргэн, захиргааны (дугуйлах) салбар эрх зүйг сонгож хууль хэрэглэх
мэдлэг, чадварын шалгалт өгөхөө үүгээр илэрхийлж байна.

Өргөдөлд шүүгчийн сонгон шалгаруулалтын зард дурдсан холбогдох баримт,
мэдээллийг хавсаргав. Үүнд:

1. хууль зүйн дээд боловсролын диплом (гадаадад их, дээд сургууль төгссөн
бол диплом болон түүнийг баталгаат орчуулгын нотариатаар гэрчлүүлсэн
хувь)
2. хуульчаар гурваас доошгүй жил ажилласан хөдөлмөр эрхлэлтийн талаарх
нотлох баримт буюу нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын
дэвтэр, эсхүл лавлагаа, өмгөөлөгчийн хувьд гурваас доошгүй жил
өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлсэн тухай нотолгоор (нийгмийн даатгалын
шимтгэл төлсөн лавлагаа, гурваас доошгүй жил өмгөөлөгчөөр оролцсон
шүүхийн шийдвэрийн жагсаалт, өмгөөлөгчийн мэргэжлийн хариуцлагын
даатгалын гэрээ зэрэг)
3. эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй тухай Цагдаагийн ерөнхий газрын
лавлагаа;
4. хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ
(хуульчийн гэрчилгээ);
5. төрийн албан хаагчийн анкет (А болон Б хавсралтын хамт)
6. Ерөнхий зөвлөлөөс баталсан маягтын дагуу гаргасан мэргэжлийн үйл
ажиллагааны танилцуулга, түүний хавсралт;
7. оршин суугаа газрын тодорхойлолт
8. Монгол Улсын иргэний үнэмлэх;
9. гэрлэлт (гэрлэсний бүртгэлтэй, эсхүл бүртгэлгүй болон гэрлэлт дуусгавар
болсон, сэргээсний)-ийн лавлагаа;

10. шүүгчийн сонгон шалгаруулалтын зард заасан материал хүлээн авах хугацаанд гаргуулж авсан шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадалгаа; /Шүүгчид нэр дэвшигчийн эрүүл мэндийн тодорхойлолт гаргах журмын дагуу бүрдүүлж ирүүлнэ.
11. Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг;
12. Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн эрхийн лавлагаа;
13. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан шаардлага хангаж байгаа тухай нотлох баримт зэргийг хавсаргав.

Хавсралт ... хуудастай.

Шүүгчид нэр дэвшигчээр бүртгүүлэхээр өргөдөл гаргасан:

Хуульч /өмгөөлөгч, прокурор, багш гэх мэт/:

...../...../

Гарын үсэг

эцэг /эх/-ийн нэр, өөрийн

нэр

Холбоо барих утасны дугаар:.....

Холбоо барих цахим шуудангийн хаяг:.....

Маягт 3Б.

НЭР ДЭВШИГЧИЙН ӨРГӨДЛИЙН ЗАГВАР
/шүүгч нэрээ дэвшүүлэх/

... оны сар-ны өдөр
хот

Улаанбаатар

.....-ны би анхан, давж заалдах (дугуйлах)
шатны шүүхийн эрүү; иргэн; захиргаа; эрүү, иргэний хэргийг (дугуйлах) харьяалан
шийдвэрлэдэг шүүхийн шүүгчийн албан тушаалд, Улсын дээд шүүхийн шүүгчийн
албан тушаалд (дугуйлах) нэрээ дэвшүүлж байна.

Миний бие Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн-т
заасан шүүгчид тавих болзол, шаардлагыг хангасан, сүүлийн зургаан жилд улс
төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй болно.

Шүүгчийн сонгон шалгаруулалтын шалгалтад нэр дэвшигчээр бүртгэсэн
тохиолдолд хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг олон нийтэд
нээлттэйгээр байршуулах, эрх бүхий байгууллагаас лавлагаа тодруулга авахад
татгалзах зүйлгүй болохоо илэрхийлж байна.

Шүүгчийн сонгон шалгаруулалтын нөөцөд бүртгэлтэй, үнэлгээ нь хүчинтэй
байгаа, тохиолдолд дахин оролцсон шалгалтын нийлбэр оноогоор
эрэмбэлэгдэхийг хүлээн зөвшөөрсөн болно. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр
дэвшигч би эрүү, иргэн, захиргааны (дугуйлах) салбар эрх зүйг сонгож хууль хэрэглэх
мэдлэг, чадварын шалгалт өгөхөө үүгээр илэрхийлж байна.

Өргөдөлд шүүгчийн сонгон шалгаруулалтын зард дурдсан холбогдох баримт,
мэдээллийг хавсаргав. Үүнд:

1. эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй тухай Цагдаагийн ерөнхий газрын лавлагаа;
2. хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ (хуульчийн гэрчилгээ);
3. төрийн албан хаагчийн анкет (А болон Б хавсралтын хамт)
4. Ерөнхий зөвлөлөөс баталсан маягтын дагуу гаргасан мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга, түүний хавсралт;
5. гэрлэлт (гэрлэсний бүртгэлтэй, эсхүл бүртгэлгүй болон гэрлэлт дуусгавар болсон, сэргээсний)-ийн лавлагаа;
6. шүүгчийн сонгон шалгаруулалтын зард заасан материал хүлээн авах хугацаанд гаргуулж авсан шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадалгаа;
7. Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг;
8. Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн эрхийн лавлагаа;
9. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан шаардлага хангаж байгаа тухай нотлох баримт зэрэг.

Хавсралт ... хуудастай.

Шүүгчид нэр дэвшигчээр бүртгүүлэхээр өргөдөл гаргасан:

Шүүгч

/:

...../...../

Гарын үсэг

эцэг /эх/-ийн нэр, өөрийн

нэр

Холбоо барих утасны дугаар:.....

Холбоо барих цахим шуудангийн хаяг:.....